

Хятад Монголын хүмүүнлэгийн харилцааны шинэ хэлбэр

1990 оноос дэлхийн улс төрийн амьдралд эрс өөрчлөлт гарч социализм, капитализм хэмээх хоёр туйлын хооронд үзэл суртлын болон хүйтэн дайны бодлого бүрмөсөн зогсож социалист лагерь нуран унасан нь Төв Азийн цээжнээ орших Монгол улсын хувьд санамсаргүй зүйл байлаа.

Монгол улсын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагтай, тоталитар дэглэмийн загсаглалаас нийгмийн хүмүүшлэг иргэний чиг шугамыг сонгон авав.

Нийгмийн энэхүү өөрчлөлтийг дагаад гадаад бодлого түүний үзэл баримтлал өөрчлөгдөж ганц тулгуурт гадаад бодлогоос олон тулгуур гадаад бодлогыг гадаад харилцааны чиг шугамаа болгов.

Олон тулгуурт гадаад бодлогын нэг тулгуур нь хөрш хоёр их гүрэнтэй тэгш харилцаж, аюулгүй байдал, үндэсний эрх ашигт нийцсэн геополитикийн бодлого явуулах үйл ажиллагаа юм.

Монгол Хятад хоёр улсын харилцаа 1990 оноос шинэ үе шатанд гарч 1990-2000 онуудад харилцан хийсэн төрийн айлчлалуудаар хамтарсан тунхаг бичгийг баталж гэрээ хэлэлцээрүүдийг байгуулсан явдал нь гадаад явдлын түвшинг илэрхийлж байна.

1. Монгол улс дахь Хядатын цагаач иргэдийн асуудал.

Хоёр улсын найрсаг харилцааны нэг илрэл бол иргэд хоорондын харилцан зорчих явдал юм. Сүүлийн 5 жил гаруй хугацаанд Монгол улсад Хятадын цагаач иргэд олноор ирж суурьших болсон. ИБМУТ-ийн 1 дүгээр улирлын дүнгээс авч үзвэл 2001 онд Монголын харъяат болсон цагаач иргэд 3050 байна.

ХИЛ СУДЛАЛ

Хятадын цагаач иргэд манай улсын Төв, Сэлэнгийн районд илүү их суурьшиж байна. Эдгээр цагаач иргэдээс 1996 онд 613, 1997 онд 361, 1998 онд 361, 191 481 өрх айл, ИБМУТ-т бүртгүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл 2618 иргэн хөдөлмөр эрхэлж байгаагаас хөдөө орон нутагт 838 хүн, Улаанбаатар хотод 1778 иргэн газар тариалан, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ, гар урлал эрхэлж байна.

Монгол улсад оршин сууж байгаа Хятадын цагаач иргэдийн боловсрол эзэмшсэн байдлыг нийслэлийн СБД-ийн 11,12-дугаар хороонд амьдрах хятад иргэдийн дунд явуулсан судалгаанаас үзэхэд Хятад иргэдийн 70 хувь нь бүрэн бус, 20 хувь нь бүрэн дунд, 7 хувь нь дээд боловсрол, 3 хувь нь огт боловсролгүй иргэд байна. (ИӨБМУТ-ийн Хятадын цагаач иргэдийг хариуцсан тасгийн 2001 оны мэдээ ИБМУТ-ийн 2001 оны мэдээнээс авав)

Монголд амьдарч байгаа хятадын иргэдэд боловсрол эзэмшүүлдэг ганц сургууль нь СБД-ийн 12 дугаар хороонд орших 9 жилийн сургалттай хятад сургууль, мөн арван жилийн 14,16 дугаар дунд суруульд хятад хүүхдүүд боловсрол эзэмшиж байна. Хятад сургуульд хичээл заадаг багш нарын боловсролын түвшинг судлан үзэхэд дээд боловсрол эзэмшсэн багш нар зонхилох хувийг эзлэх боловч бүрэн бус дунд боловсролтой иргэд хичээл зааж байгаа явдал ч бий. Дээд боловсрол эзэмшсэн иргэд бүгд хэлний мэргэжилтэн, орчуулагч болон төгсөөд мэргэжлээрээ ажиллаж байгааг нь дээрх судалгааны дүн харууллаа.

Оршин суугч цагаач иргэдийн эрхлэх аж ахуй хөдөлмөр эрхлэлтийн хувьд авч үзвэл нийгмийн бүхий л салбарт хөдөлмөрлөж нэг өрх айлын сарын дундаж орлого нь өөрсдийнх нь мэдүүлж байгаагаар 50,000 төгрөг ажээ. Гэтэл оршин суугчдын амьдралын түвшин Монгол өрх айлын дундаж түвшингээс дээгүүр байгаа нь илт байна.

Жишээ нь байшингийнхаа гадна сансарын антенн зоочихсон, машин зогсоочихсон, хятад хоолны газрыг нээн ажиллуулсан байгаа гэж ярих цагаач иргэд сард 50,000 төгрөг олдог гэх нь үнэхээр инээдэмтэй санагдаж байна.

Монголд цагаачлан ирсэн хятад иргэдийн 97 орчим хувь нь БНХАУ-ийн Хэбэй мужийнх байдаг бол үлдэж буй цөөнх хувь нь Китань муж, Хөх хотын уугуул иргэд ажээ. Төрөлх нутаг БНХАУ руугаа иргэн бүр жилд дунджаар 3 удаа эмчлүүлэх, наймаа хийх зорилгоор явдаг гэж тайлбарладаг.

Монгол улсад оршин суух ногоон өнгийн паспортыг 2002-2003 он хүртэл сунгуулсан ба 70 наснаас дээш өндөр настангуудын паспортыг сунгадаггүй юм байна. БНХАУ-ын ЭСЯ-наас олгосон гадаад улаан паспортыг давхар эзэмшиж байгаа явдал нь цагаачлах асуудлыг эрхлэх төрийн зөвлөлийн явуулж буй нэг нууц үйл ажиллагааны нотломж мөн.

Эдгээр цагаач иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, боловсрол мэдлэг, мэдээлэл олж авах явцыг нь анхаарч 1997 онд засгийн газрын шийдвэрээр хятадын цагаач иргэдэд регистрийн дугаар, паспорт олгож харьяат иргэн болгох асуудлыг зохион байгуулахыг ИБМУТ-д үүрэг болгосны дагуу 1998 оны 12 дугаар сарын 10-наас эхлэн 2560 хүнд регистрийн дугаар олгож Монголын харьяат болгосон байна.

Монгол улсад оршин суугч Хятадуудын эрхийг хамгаалах □Бүр эрхийг Хятадуудад□ хэмээх төрийн бус олон нийтийн байгууллага ХЗДХЯ-наас албан ёсоор зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа явуулж энэ байгууллагыг ИБМУТ-ийн газрын дарга хурандаа Гарьд толгойлдог ажээ. Энэ байгууллагын зорилго нь ажил хэрэгч томоохон хятадуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр Монголын нийгэмд дуу хоолойгоо гаргаж, Хятадуудад нийгэм улс төрийн давуу эрх олгох явдал гэж судлаачийн хувьд үзэж байна. БНХАУ-ийн Засгийн газрын гадаадад цагаачлан гарах асуудлыг хариуцсан Төрийн зөвлөлийн эрхлэх үйл ажиллагаа нь цагаач иргэдээ тал бүрээс дэмжиж тусламж үзүүлэх ба тусгай үүрэг даалгавар өгөхөд чиглэгджээ.

Энэ нь хөрш орон болох Хятадтай тогтоосн найрсаг харилцааны илрэл, хүний эрхийг хүндэтгэсэн явдал боловч Монголд цагаачлан ирэх хятадуудыг даллан ирүүлж амьдрах бололцоогоор хангасан тухайн үеийн засгийн газрын алдаатай бодлого болсон юм.

ХИЛ СУДЛАЛ

ХЦУГ-ын 1999 оны эцсийн дүнгээс авч үзвэл албан ажлаар 8365 иргэн, 26011 иргэн хувийн ажлаар, жуулчлалаар 1026 хүн, байнгын оршин суухаар 1724 иргэн, бусад ажлаар 2328 хүн Монгол улсад орж ирсэн байна.

ЦЕГ-ын мэдээнээс авч үзэхэд иргэд нь манай улсын нутаг дэвсгэр дээр гэмт хэрэг үйлдэх, нэг нэгийг зодож гэмтээх, амь насыг нь хохироох, залилах явдал 1998-1999 оныхоос 30% өсчээ. Жишээ нь 1999.09.06 өдөр хилийн 44 тоот тэмдгээр Баян - Өлгий аймгийн нутгаар хил зөрчин орж ирсэн Цэвлээгийн Бат, Лхамжавын Баяр нар Сэлэнгийн Орхонтуулд нуугдаж байсныг баривчилж 2002 оны 12 дугаар сард албадан гаргасан. 1997 оны 2 дугаар сард иргэн Мөнхөө нь Монголын иргэн Баярсайханаас 13 сая төгрөг залилан авсан. Монгол улсын тагнуулын байгууллагад шалгагдаж байгаа хэрэг бүрдүүлэх, мөрдөн байцаалтаас оргон зайлсан Линь -Шү Линьг хилээр гарч явахад нь албадан саатуулан одоо хэрэг нь хянагдаж байна.

АНУ-ын хөрөнгө оруулалттай "Тинпер", "Германы индустриал" хэмээх хамтарсан үйлдвэрт ажиллаж буй БНХАУ-ын 6 иргэний 2 нь огт зөвшөөрөлгүй, 4 нь бүртгэлийн зөрчилтэй гэх мэт олон хэргүүдийг дурьдаж болно. БНХАУ, Монгол улсын хооронд байгуулсан хилийн гэрээгээр 2 улсын хилийг 5 жил тутамд 1 удаа хамтран шалгаж байсныг сүүлийн 12 жилд шалгаагүй байна.

2.Монгол улс Хятадын бэлтгэн борлуулагч зах зээл болсон нь

Гаалийн Ерөнхий Газрын 2000 оны эцсийн дүнгээс үзвэл Монгол улс дэлхийн 57 оронтой экспортын худалдаа хийснээс экспортын 57,1 хувь импортын 15 хувийг Хятд улстай хийж байна. Үүний дотор экспортолсон зэсийн баяжмалын 89,8-ыг, бохир ноолуурын 31,3 хувийг Хятадад гаргажээ.

Монгол улс нийт 4 сая ам долларын бараа гаргаснаас 0,005 сая ам долларын бохир ноолуурын, 0,007 ам долларын хивсийг хятадад гаргасан байна. Олон улсын эдийн засгийн байгууллага, хандивлагч орны тусламжтайгаар 54,4 сая импортын барааг гадны

хөрөнгө оруулалтаар хамтарсан үйлдвэрийн дүрмийн санд нийлүүлснээс БНХАУ-д 4,6 хувь оногдож байна.

Манай улс дэлхийн 57 орны барааг импортолсноос 15 хувийг нь хятадаас импортолсон байна. БНХАУ-аас импортолсон гол нэрийн түүхий эдийн тоо ширхэгээр доллароор үнэлэн тооцвол:

- үхрийн хөлдүү мах – 82,50тн, 32,0 сая ам доллар
- малын дайвар бүтээгдэхүүн – 194,80 тн, 85,7 сая ам доллар
- адууны дэл сүүл – 273,2 сая ам доллар
- бог малын болон гэдэс – 218,63 тн, 411,6 сая ам доллар
- ясны гурил – 6233,26тн, 145,4 сая ам доллар
- бугын ясан эвэр – 22,83 тн, 145,4 сая ам доллар
- түүхий нефть – 3365990 тн, 920,9 сая ам доллар
- ямааны бохир ноолуур – 762,45 тн, 13996,0 сая ам доллар
- ямааны самнасан ноолуур – 348,85 тн, 12129,8 сая ам доллар

Дээрх тоо баримтаас үзэхэд Монгол улс хятадын үйлдвэрүүдийг түүхий эдээр хангаж байгаа нь илт байна. Гэтэл манай улсын аж үйлдвэрүүд түүхий эдгүйгээс зогсож, үндэсний үйлдвэрлэл унасан явдал нь Монгол улсын эдийн засагт ноцтой хохирол учруулсаар байна.

Хятадын талаас өнөөдөр Монгол улсын зах зээлд оруулж буй хөрөнгө оруулалтын салбар нь хамтарсан гэх нэрийн дор оёдлын үйлдвэр, нийтийн хоолны сүлжээ байгуулах, бага хэмжээний зээл олгох төдийхнөөр хязгаарлагдаж байна. Энэ салбар бол туслах аж ахуйн шинж чанартай болохоор үндэсний үйлдвэрүүдийг сэргээн босгох, хүнд металлын үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулалт хийхгүй байгаа.

Монгол улс дэлхийн ноолуурын 25 хувийг дангаараа бэлтгэдэг. Монголын ноолуур дэлхийн чанарын стандартад тохирч, цагаан алт гэж зүй ёсоор нэрлэдэг билээ. Гэтэл БНХАУ нь Монгол ноолуурын ханшийг дэлхийн зах зээл дээр зориудаар унагаж, ямааны арьс ноолуурын үнийг зохиомлоор хөөрөгдөж Монголын ямааг устгах бодлогыг явуулж байгаа юм.

Мөн хятад улс руу түлшний мод, зүсмэл металлыг өдөр шөнөгүй вагоноор зөөж байна. Хятад улс ой модны асар их нөөц

ХИЛ СУДЛАЛ

баялагтай, хянганы их нарсан ой, өмнөд мужийн шилмүүст ой дэлхийд алдартай. Түүнийг “Азийн уушиг” гэж нэрлэдэг. Монгол улс газар нутгийнхаа 0,6%- тай тэнцэх ойтой атлаа ой модыг хайр найргүй сүйтгэж, урд хөршид нийлүүлж байгаа нь экологийн тэнцвэр, байгалийн унаган төрх алдагдаж байна. Энэ мэт үйл ажиллагааг хуулиар зохицуулж шийдвэрлэх хэрэгтэй байна.

*ХЦДС-ийн ШНА-эрх зүйчийн гуравдугаар
дамжааны сонсогч Ц.Нямгэрэл*